

болгож, бүх нийтийн аюулгүй байдал, тэгш эрх, зэвсэг хураах, бүх улсуудын хооронд энх тайван, хамтын ажиллагааг хангахын төлөө идэвхтэй тэмцэж байна.

1. Ленин В. И. Пробуждение Азии. -Зохиолууд, 19-р боть. х. 66
2. Потанин Г. И. Путешествие по Монголии. Изд-во географической литературы, 1948 с. 358
3. Ширендыб Б. Монголия на рубеже XIX-XX вв. УБ, 1963 с. 145
4. Майский И. М. Монголия накануне революции. Изд-во Восточной литературы. М. 1959 с. 269-274
5. «БНМАУ-ын түүх» Нэгэн боть, нэмэн засварласан 3 дахь удаагийн хэвлэл, УХГ УБ, 1984
6. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УХГ, УБ, 1978
7. Монгол ардын шог хошин үлгэр. УХГ, УБ, 1984 х. 190—198

МОНГОЛЫН 1911 ОНЫ ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДАГЧ

Л. ЖАМСРАН

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Монголчууд Чин улсын ноёрхолыг бүр анхнаас нь эхлэн эсэргүүцсээр ирсэн нь XIX зууны сүүлчээс нэн идэвхжиж XX зууны эхний арван жилд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон төлөвшсөн юм. Түүний өрнөлтийн дээд туйл нь 1911 он байсан тул 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэж товчоор нэрлэж байна.

Чин улсаас салж Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээх хэргийг санаачилж, удирдан зохион байгуулагч нь хэн байсныг Монголын түүх судлал тусгайлан судлаж нэгэн мөр болгоогүй байгаагаас XX зууны эхний Монголын түүхээр гарсан бүтээлүүдэд янз янзаар бичсэн байдаг. Тэдгээрийг өрөнхийд нь хоёр ангилж болно. Үүнд: 1. Монголд 1911 онд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөсөн. Түүнийг Жибзундамба хутагт тэргүүтэй Монгол феодалууд удирдсан, хөдөлгөгч хүч нь Монголын ард түмэн байсан. 2. XIX зууны эцэс XX зууны эхээр Монголчууд үндэснийхээ эрх чөлөөний төлөө босч тэмцээгүй, зөвхөн хаант Орос улсын хатгалгаар Жибзундамба хутагт тэргүүтэй цөөн феодал урваж, тусгаарласан гэж Чин улсын ноёрхолыг зөвтгөж Монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг үгүйсгэж, түүх гуйвуулсан байдаг.

Энэ хоёр үзлийн адил тал нь Жибзундамба хутагтыг 1911 онд Монголд болсон хэрэг явдлын удирдагч гэж үзэж байгаа явдал мөн. Гэтэл Жибзундамба хутагт бол Чин улсын төрөөс Монголчуудыг шарын шашны суртлаар мунхруулан барьж байх үүрэг хүлээсэн, тавиулын этгээд, харийн хүн билээ. Тус улсын түүхийн Төв Архив дахь баримт хэрэглэгдэхүүнийг үзэхэд, Жибзундамба хутагт Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээх явдлыг анх санаачлан, түүний төлөө тэмцэгч, олон нийтийг зохион байгуулагч биш байжээ. Харин тэр хэргийг жинхэнэ санаачлан зохион

байгуулагчид нь Богдын нөлөө, нэр хүндийг ашиглан уг хэргийг явуулж байсан учраас Богд бүхнийг хийсэн мэт болжээ гэдэг ойлголт төрдөг.

Монголын 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний жинхэнэ удирдагчийн тухай асуудлыг судалгааны үндэстэй тодруулан гаргах нь зөвхөн түүхэн үйл явдлын бодит үнэнийг илрүүлэх төдийгүй их гүрний дээрэнгүй бодлогын үүднээс Монголын ард түмний түүхийг санаатай завхруулагчдад нэгэн мөрийн няцаалт болох чухал ач холбогдолтой юм. Иймд энэ өгүүлэлд Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний явцад дэвшигдэн гарсан удирдагч нь хэн байсныг тодруулахад өөрийн саналыг нэмэрлэхийг оролдов.

I

Монголын 1911 оны үйл явдлыг бичсэн бүтээл бүхэнд чин ван Ханддоржийн нэр гардаг боловч түүнийг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гол удирдагч гэж бараг бичдэггүй. Гэтэл архивын баримт хэрэглэгдэхүүнийг үзэхэд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчдын дотор Ханддорж зонхилж байсныг нотлох баримт цөөнгүй байгаагийн заримыг авч үзье.

Ханддорж 1869 онд Халхын Хойт замын баруун гарын зүүн хошуу (одоогийн Булган аймгийн Төв, Орхон, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Сайхан зэрэг сумын хавь)-нд Түшээт хан аймгийн засаг, хошой чин ван Цэрэндоржийн ахмад хүү Мижиддоржийн гэрт төрсөн гэдэг. Эцэг Цэрэндоржийнхоо хэргэм зэргийг залгамжлах ёстой Мижиддорж өвчнөөр эрт бие барсан тул түүний хүү Ханддорж 1892 онд өвөг эцгийнхээ засаг, хошой чин вангийн хэрэгмийг залгамжилсан ажээ.* Тэр 1897 онд Чин улсын эзэн хааны зарлигаар Түшээт хан аймгийн туслагч жанжингийн хэбэй (зөвлөх), 1900 онд жинхэнэ туслагч жанжнаар тус тус томилогдсон¹. Залуу ноён ийнхүү тушаал дэвшиж байсан тэр үед Чин улсын засгийн газар Монгол нутаг дээгүүр төмөр зам тавиулах, түүний ашигт малтмалыг эзэрхэг түрэмгий улсуудад эзэмшүүлэх ил далд явууллага хийх болсон нь Монголчуудыг зүй ёсоор түгшүүлсэн ажээ. Иймд Халхын дөрвөн аймгийн чуулганы дарга, жанжин, дэд да, хэбэй, Хүрээний Эрдэнэ Шанзудба нар нэр холбож 1899 онд Их Хургаанд бичиглэж Халхын нутаг дээр гадаадын хүмүүс алтны уурхай нээн ашиглахыг эсэргүүцэхийн хамт Улиастайн жанжин, Хүрээний сайд нар Монголчуудын санал хүслийг харгалзахгүй байгааг илчлэн мэдүүлэхдээ: «... олон ядуу монголчууд гадаад хүнд зарцлагдан боолчлогдох, элдэв самуун хэрэг үүдэж, улсын үндсэнд хохиролтой болох болов уу? хэмээн эмээлцэнэ»² гэсэн байдаг. Энэ зарга тэмцэлд Ц. Ханддорж оролцсон. Мөн Улиастайн жанжин Монголчуудад дааж давшгүй алба гувчуур оногдуулж элдвээр дарлаж байгаа тухай Жалханз хутагт, Ялгуусан хутагт нартай нэр хамтлаж Ханддорж Их жургаанд гомдол мэдүүлэхдээ; «Хэрэв хэрэг явдал цаашид ийм байвал Монголчууд зэвсэг барихаас өөр аргагүй»³ гэж Чин улсын эрх баригчдад анхааруулж байсан байна.

Английн цэрэг Төвдөд цөмрөн ороход Далай лам Түвдэнжамц дайжиж, Орос улстай холбоо барьж, тусламж эрэх хэргээр 1904 оны 11-р сард Ар Монголын хүрээнд хүрэлцэн ирж Оросын консулаар дамжуулан Орос улстай холбоо барихын сацуу Монголын эрх баригчидтай харилцаж

* Тэр үеийн бичиг баримтад Мижиддоржийн нэр бараг дурдагдахгүй, өвөг эцэг Цэрэндорж нь байнга гардаг тул Ц. Ханддорж гэж бичив.

улмаар Ц. Ханддоржийн заллагаар Вангийн хүрээнд очиж өвөлжсөнөөс гадна Заяын хүрээнд бас айлчилсан юм. Ц. Ханддорж Далай ламыг Монголд байхад ойр дотно харилцаатай байснаас гадна 1906 онд түүнийг Бээжин рүү явахад нэгэн хүүгээ хамт явуулсан ажээ. Гэтэл Чин улсын төр Дэнзэнжамцыг* эзэн хааны ордонд ёс бусаар нэвтрэн орсон гэдгээр шалтаг хийж баривчлан хорьсонд Д. Ханддорж биеэр Бээжинд очиж хүүгээ аврах гэж элдвээр оролдсон боловч амжилт ололгүй цаазлуулсан. Тэгээд Чин улсаас салан тусгаарлахын төлөө тэмцэхээ тангараглаад буцаж ирсэн гэж тэр үед амьдарч байсан хүмүүс бичсэн байдаг.**

Чин улсаас Монголын талаар явуулдаг бодлого эрс өөрчлөгдөж гадаадын капиталыг Монголд нэвртүүлэх болгосноос гадна Монголчуудыг Хятадчилж, нутаг бэлчээрийг нь шууд хагалбарлаж, хятад байгууллага байгуулж эхэлсэн нь Монголын феодалуудын эрх ашигтай харшилж байсан тул Чин улсын бодлогод дургүйцэн эсэргүүцэж байсан Ц. Ханддоржид хүүгийг нь хороосон Чин улсын цадиггүй аллага маш их хорсол төрүүлж, Монголын тусгаар тогтнолыг сэргээхийн төлөө гуйвалтгүй тэмцэ хэд нь түлхэц болсон ажээ.

Чин улсын засгийн газар XX зууны эхнээс Монголд «шинэ засгийн бодлого» гэгч дээрээс хийх шинэчлэлээ хүчлэн дэлгэрүүлэх болсон юм. Түүний гол агуулга нь ялзран доройтож буй Чин улсын эзэнт хаант феодалын төрийг хамгаалж хадгалахын тулд юуны урьд газаргүйн улмаас бухимдан эсэргүүцэгч хятад үй олон тариачдыг монгол газар ирүүлж, бэлчээр хагалбарлуулан суурьшуулах, тэднийг харьяалах хятад захиргаа байгуулахаас эхлээд, хятадын худалдаа үйлдвэрийн этгээдүүдийг ирүүлж ахуй, үйлчилгээ, үйлдвэр худалдаа, тээврийн зэрэг олон байгууллага байгуулж, хуучин хууль тогтоомжийг халж өөрчлөн хятадчилахад оршиж байв. Ийм нөхцөл байдалд Чин улсын ноёрхолын эсрэг Ц. Ханддоржийн улс төрийн үйл ажиллагаа мэдэгдэхүйц идэвхжсэн юм. Чин улс шинэ засгийн бодлого гэгчээр төлөвлөсөн арга хэмжээнүүдээ хэрэгжүүлэхийн өмнө Монгол аймаг, хошуудаар олон зүйлийн судалгаа ялангуяа, Монголчуудын тарианы газрын хэмжээг гаргуулаад, тэдгээрийг зөв гаргасан эсэхийг магадлан байцаах манж, монгол түшмэдийг 1907 оны зун Халхын аймаг, хошуудад томилон явуулсан. Тэгэхэд Түшээт хан аймгийн жанжин, чин ван Ханддоржийн хошууны эрх баригчид, зарлигаар за-

* Л. Дашням тэр хүүгийн нэрийг «Дашдоо» гэж дам дуулсан гэж дурсамж тууждаа бичжээ. (Өлзийнарангийн өчил. УБ. 1974, 28-р талд) БНМАУ-ын Түүхийн Төв Архивт байгаа чин ван Ханддоржийн хэргэм залгамжлуулах хүний тухай 1909 онд бичсэн нэгэн албан бичигт түүнийг гурван хүүтэй байсан гээд ахмад хүү Дашдорж мөн онд өвчнөөр бие барсан. Хоёрдугаар хүү Дэнзэнжамц урьд нэгэнт бие барж зохих газар мэдүүлсэн. Гуравдугаар хүү Жамбалдоржийн бие Бадруулт төрийн 26-р (1900) оны зуны сүүл сарын 18-нд төрсөн» гэжээ. (УТТА. ФМ-9. ХН-4038) Иймд Далай ламыг дагаж Бээжинд явсан хүү бол Дашдоо буюу Дашдорж биш Дэнчинжамц (Дэнзэнжамц) мөн.

**Б. Жамбал энэ тухай дурсахдаа: Ханддорж вангийн уур нь хүрч <<Манж Хятадын шаахайны мөрийг жанжхүүгийн даваанаас нааш гаргахгүй гэж тангарагласан юм гэдэг (Өвгөн Жамбалын яриа УБ., 1959. 52-рт) А. Дашням, бичихдээ: « . . . Ханддорж Чин ван өгүүлэшгүй их үй гашуунд унаж, отго жинст малгайгаа авч ширээн дээр шидэж, амьд ахуй цагтаа танай Манж Хятадын маалинга шаахайн ул, Марал илжгийн туурайг Хаалган даваа (Чуулалт хаалга буюу Жанчхүүгийн даваа) давуулах, Ар Халхын нутагт хэрхэвч гишгүүлэхгүй хэмээн ам тангараг андгайлан нутагтаа буцаж ирсэн» гэжээ. (Өлзийнарангийн өчил) 34-рт. Түүнчлэн Ханддорж чин ван жинстэй малгайгаараа газар гуядаж жасааны яам Төвдөөс залахгүй, Жанчхүүгийн даваанд шаахайн мөр гаргахгүйгэсэн хэмээн өндөр настангууд ярьдаг.

рагдсан тэдгээр түшмэдэд өртөө унаа нийлүүлэхээс татгалзаж Хүрээний сайдын яаманд тамгагүй цагаан бичиг ирүүлээд уг албыг тасалдуулсан байна.⁵ Түүнчлэн Чин улсын захиргаа 1909 оны сүүлчээр Халхын бүх аймаг, хошуудаас 18 зүйлийн чухал судалгааг хугацаа тогтоож гаргуулахад Түшээт хан аймгаас мөн Ц. Ханддоржийн хошуу зэрэг таван хошуу тогтоосон хугацаанд нь гаргаж өгөөгүй ажээ.⁶ Эдгээр нь тус хошууны засаг Ц. Ханддоржийн улс төрийн үйл ажиллагаатай холбоотойгоос гадна Монголчууд өөрсдөө хичнээн хэмжээний газар тариа тарьдагаа Чин улсын захиргаанд мэдэгдэхгүй байх, цаашид нутаг бэлчээрээ хятадын тариалангийн талбай болгох дургүй байсны баримт мөн.

Халхын Түшээт хан, Сэцэн хан аймаг ба Их шавийн эрх баригчид Чин улсын шинэ засгийн бодлогыг эсэргүүцэхдээ 1909 оноос эхлэн засагт хан, сайн ноён аймгийн эрх баригчидтай хамтрахыг оролдсон байдаг. Д. Ханддорж харьяат чуулгынхаа да, дэд да, Түшээт хан нарт шинэ засгийн бодлогыг эсэргүүцэж 1910 оны өвөл ирүүлсэн бичигтээ: «... энэхүү тариа хагалах хэрэг угаас манай Монголчуудад харштай хэмээн эртнээс нааш цааз бүхий хэрэг бөгөөд хэдэн удаа хагалахыг байлгасан нь одоо нэгтэй ийнхүү хагалах аваас зүйл зүйлийн харштай төдийгүй, харин газар газрын муу иргэд нэмэн хуралдсаар эцэстээ шашин төрийн үндсэнд онц харштай будлиан болж хохирох чирэгдэхээс хэлтрэх нэн бэрх тул одоо чухам хэрхвээс зохихыг эдүгээгээс даруй яаравчлан зөвлөлдөж шийтгэж вээс зохих тул... нөгөө хоёр тэргүүн засагт хан, сайн ноён аймгийн А. ж.)-тэй яаравчлан зөвлөлдөж гүйцэтгэн шийтгэх ажаамуу»⁷ гэжээ.

Жанжин Ц. Ханддоржийн энэ саналыг Хан уулын чуулганы да, дэд да, Түшээт хан нар хянан үзээд саналыг «... даруй үнэнтэй болохын дээр мөн энэ хэргийн дотор иргэд, (хятад-Л. ж) монгол харилцан худ болж үл болохыг хувьсгана хэмээх нь хэрэв ийнхүү худ боллоцоход хүрэх аваас... иргэд, монгол харилцан сүлбээлж ядуу монголчуудыг яахин гэнэдүүлж, хэрхэн зовлон зүдүүрт холбогдуулахыг ер үгүй болгоход бэрх тэй бөгөөд чухам хэрхэвээс харш будлиангүй болж хуучин журмаар аж төрж болохыг зүй нь бидний тэргүүнүүд бүгдээр зөвлөлдөх нэгэн болгон тогтоосон тухайд нөгөө аймгуудад зөвлөлдөх зэргээр хянан тогтоовоос зохих ... » гэсэн байна⁸

Түшээт хан аймгийн эрх баригчдын эдгээр бичигт Чин улсын шинэ засгийн бодлогын ноцтой зарим гол зүйлийг Халх даяар хүчээ хамтатгаж эсэргүүцэх санал дэвшүүлэхдээ Монголын феодалын үндэсний үз лийг илэрхий агуулсан байна. Чухам энэ үзэл л Монголын феодалууд, Чин улсын ноёрхолын эсрэг хамтран тэмцэх үзэл суртлын үндэс болж байжээ. Ц. Ханддорж зэрэг Түшээт хан аймгийн эрх баригчид шинэ засгийн бодлогыг эсэргүүцэхдээ Жибзундамба хутагтын нөлөөг ашиглаж байсан тул Жибзундамба хутагт 1911 оны цагаан сард буулгасан нэгэн лүндэндээ: «... жанжин чин ванд захиж шаардах нь; Хутагт би одоо гийн шинэ засаг хэмээгчийн дотор тарианы зэрэг газар оронд онц харштай зүйлийг хамт нийлэн, учир гарган мэдүүлтүгэй... Одоо энэ амбанд (Хүрээнд байгаад бүрмөсөн буцах гэж байсан Манж сайд Янь Чжи. -Л. Ж.) эдүгээ даруй дэлгэн мэдүүлэхгүй болбоос шууд нээн шийтгэхийг завдаж бүхий мэт сонсогдоно. Битгий дэмий үхээнцэр бэрхшээн хойргошигтун! Үүний тулд ойрыг үзэж жанжин чин ван, хамаарсан да нарт тус тус шаардах хуудас өгөв»⁹ гэжээ. Үүнээс үзэхэд Ц. Ханддорж бол Чин улсын шинэ засгийн бодлогын эсрэг тэмцэлд Жибзундамба хутагтыг та тан оролцуулах, халх нийтээр уг асуудлыг хэлэлцэх санал гаргасан хүн гэдэг нь илэрхий. Үүний дараахан Хан уулын чуулганы хамаарсан да,

дэд да, Түшээт хан нар Хэрлэн Барсын чуулганы эрх баригчдад жан жин чин ван Ханддорж, богд Жибзундамба хутагт нарын эдгээр санал, зөвлөлгөөг уламжилж улмаар Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгаас тусгай түшмэл томилон гаргаж 1911 оны 2-р сарын 5-нд Хүрээн дэх Түшээт хан аймгийн суурин жасааны газраа хамт хэлэлцэн Хүрээний Манд амбанд өргөх бичгийн эхийг зохиолгоё гэдэг санал тавиад хэрхэн шийдсэнээ чин ван Ханддоржид яаравчлан мэдэгдэхийг хүссэн байдаг.¹⁰

Энэ бүх баримт Ц. Ханддорж Чин улсын бодлогыг XIX зууны шувтрага XX зууны эхнээс зөвхөн өөрөө дургүйцэн эсэргүүцэж байсан төдийгүй, түүний эсрэг ар Монгол дахиныг зохион байгуулж хөдөлгөхдөө Жибзундамба хутагтын нөлөөг ашиглах алхам хийж эхэлснийг харуулж байна.

II

Ц. Ханддорж бол Ар Монголын нөлөөтэй том ноён төдийгүй хүний хүч тэнхээ, эр зориг, эрдэм ухаан, аж ахуйчлалын шилдэг аргыг хүндэтгэн харьяат хошуундаа дэмжиж хөгжүүлэх талаар санаа тавьдаг. Ер нь шинийг эрэлхийлдэг монгол, манж, хятад хэл бичиг зэгсэн мэддэг тухайн үедээ боловсрол, чадвартай хүн байсан ажээ. Иймээс Чин улс Монголд шинэ засгийн бодлого гэгчээ хэрэгжүүлэх ажилд, түүнийг татан оролцуулж уг ажлаа явцтай болгохыг элдвээр оролцож байв. Чин улсын цэргийн зөвлөлийн яам (Цзюньцзыфу) Хүрээний хамаарсан сайд Сан Догийн саналаар Хүрээний цэрэг бэлтгэх газар гэгчийг 1910 онд байгуулж Монгол цэргийг түүнд харьяалуулан Түшээт хан аймгийн жанжин Ц. Ханддорж, Сэцэн хан аймгийн жанжин нарыг Хүрээний цэрэг бэлтгэх газрын хамт нийлж шийтгэх түшмэл болгосон.¹¹ Бас Хүрээний хагалах бүгд хороо (газар хагалбарлах ерөнхий хороо-Л. Ж)-ны Монгол ерөнхийлөн захирах түшмэлээр томилсон.¹² Түүнчлэн Чин улсын хааны зарлигаар чин ван Ц. Ханддоржийг 1911 оны намар Бээжинд хуралдах Засагт тус хийх яамны хуралдаанд Ар Монголоос оролдох хэлэлцэгч түшмэлээр томилсон.¹³ Гэтэл Ц. Ханддорж Чин улсын засаг захиргааны өөртөө татах гэсэн энэ мэтийн ялууллагад автагдалгүйгээр уг албан тушаалыг урвуулан ашиглаж шинэ засгийн бодлогыг Ар Монгол нийтээр эсэргүүцэх явдлыг зохион байгуулж үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд нийт Монголчуудыг хамруулах талаар эрчимтэй ажиллах болсон ажээ. Ер нь тэр үед Түшээт хан аймгийн эрх баригчид, Халхын бусад аймаг, Их Шавийн дунд тэргүүлэн зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж байв. Түшээт хан аймгийн жанжин Ханддорж нарын зэрэг эрх баригчид, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноён аймгийн эрх баригчдад шинэ засгийн бодлогын тухай асуудлыг дараа жил Жибзундамба хутагтад даншиг өргөх ялдамд хүрээнд цугларч зөвлөлдөн тогтоох санал тавьж түүгээрээ харилцан зөвлөлдөж хариу ирүүлэхийг 1910 оны 4-р сард хүссэн байна.¹⁴ Энэ мэтээр Ар Монголын эрх баригчид өнгөн дээрээ шинэ засгийн бодлогыг Монголд хэрэгжүүлэх талаар хэлэлцэж буй дүр үзүүлээд хэрэг дээрээ эсэргүүцэх тухай харилцан зөвлөлдөх маягтай өөр хоорондоо харилцаж байснаас гадна 1910 онд Чин улсын Засагт тус хийх яамны анхдугаар хуралдааны үеэр Бээжинд очсон Ар, Өвөр Монголын хэлэлцэгч түшмэл нар шинэ засгийн бодлогыг хамтран эсэргүүцэх санаа сэдэж байсан, түүнээс урьд хожид Түшээт хан, Сэцэн хан аймгийн эрх баригчид болон Жибзундамба хутагт нар Сан-До-г Хүрээний сайдын

тушаалаас огцруулахыг Их Жургаанд удаа дараа бичиглэн мэдүүлж шаардаж байсан нь хэрэг дээрээ Чин улсаас салан тусгаарлах үндэсний эрх чөлөөний тэмцэлд феодалууд оролцсоны илрэл, өөр хоорондоо нэгдэж нятграх явц байв.

Сайн ноёны аймгийн да, жанжны газраас 1911 оны эхээр Халхын гурван аймаг, Их Шавийн эрх баригч нарт шинэ засгийн бодлоготой холбогдуулан санал гаргахдаа: «...эл явдалд бидний аймаг, шавь эрхтэнээ зөвлөлдөн очирдарь багш Богд гэгээн танаа лавлан айлтгаж нэгэн тулгуур олж, тэр тухайд нь цаг шүүмжлэлгүй болгоон тогтоовоос ямар?»¹⁵ гэсэн байна. Түшээт хан аймгийн эрх баригчид Сайн ноёны аймгаас ийнхүү санаа гаргаж зөвлөсөн нь үнэхээрийн зүйтэй хэрэг бөгөөд одоо бидний дөрвөн аймаг, шавь энэхэн үест шаламгайлан завдаж хуралдан нэгэн болговоос зохих тул уудам хүрч хүрэлцэхийг бодож энэ оны таван сарын хорин таван (6-р сарын 21 Л. Ж)-д Хүрээний газраа нэгэн зэргээр цуглаж хамт нийлж гүйцэтгэн шийтгүүлье.¹⁶ гэсэн байна.

Тэр үеийн Монголын нийгэмд үндэсний хөрөнгөтөн, пролетари нар байсангүй. Иймд Чин улсын ноёрхолын эсрэг үндэсний эрх чөлөөний тэмцлийг эх оронч санаа сэтгэл бүхий феодалууд толгойлох болжээ. Тэгэхдээ тийм феодалууд ард түмний дотор шашин шүтлэгийн талаар үлэмж нөлөөтэй богд Жибзундамбыг Чин улсын төрд үйлчлэхээс нь хөндийрүүлж өөрсдийн зорилгод ашиглах гэсэн нь Сайн ноён аймгийн эрх баригчдын гаргасан энэ саналаар давхар нотлогдож байна. Манжийн байлдан дагуулагчид Монгол орныг эзлээд аймаг, хошуу зэрэг засаг захиргааны олон адил хуваарьт оруулсан тул нийт Монголчууд тэр ч байтугай ар, өвөр, баруун монголын алинд ч улс төрийн нэгдмэл захиргаа байсангүй. Харин Жибзундамба хутагт бол Ар Монголын шарын шашны тэргүүн төдийгүй баруун ба өвөр монголд мэдэгдэхүйц нөлөөтэй байв. Нөгөө талаар Чин улсын төрөөс Монгол, Төвдийн шарын шашныг дэмждэг бодлого нь аажмаар саарч, шинэ засгийн бодлого гэгч нь шарын шашны нөлөөг эрс бууруулж хязгаарлах болсон тул Жибзундамба хутагт Монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнтэй ямар нэгэн хэмжээгээр нэгдэж байр сууриа бататгахыг хичээх болсон ажээ.

Товлосон хугацаандаа Халхын дөрвөн аймаг. Их Шавийн эрх баригчид Жибзундамба хутагтад бат оршил өргөх ялдар Хүрээнд цугларахад чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд нар тэргүүлэн, тэдний нууц зөвлөлгөөнийг Эрдэнэ Шанзудбын яаманд эхлүүлж шинэ засгийн бодлогыг хэрхэх тухай хэлэлцүүлсэн байна. Тэр завсар жанжин Ханддорж, түшээт хан аймгийн чуулган дарга Чагдаржав, да лам Цэрэнчимэд нарын хэдэн хүн Богд хан уулын модонд нууц хурал хийж «...Чин улсын засаг маш буурч ховдоглон мөлжих ба газар орны эрх ашгийг зүйл зүйлээр булаан эзэрхэх нь үнэхээрийн тэсэшгүй учир, зүй нь тусгаар тогтнож шашин, үндэс, газар орноо баталбаас зохих боловч гадаадын тусламжгүйгээр өөрөө тогтноход бэрхтэй тул хөрш Орос улсад найртай сайны ёсоор учрыг гаргаж туслан хамгаалахыг...»¹⁷ гуйх санал сэдэж шинэ засгийн бодлогыг хэлэлцэж байгаа ноёд, лам нарт илтгэсэнд хуралдагчид зөвшөөрөн сайшааж, Орос улсаас тусламж эрэх төлөөлөгчөөр чин ва Ханддорж, да лам Цэрэнчимэд, өвөр монголын түшмэл Хайсан нарыг томилон явуулахаар тогтоод богд Жибзундамба хутагтад айлтгаж зөвшөөрүүлэн Орос улсаас тусламж гуйж, Жибзундамба хутагт, Халхын хан нарын гарын үсэг бүхий албан бичиг авч явсан юм. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Халхын хар шар феодалын төлөөлөгчдөөс гада Өвөр Мон-

голын түшмэл оролцсон явдал бол үндэснийхээ нэгдэл, төрийн тусгаар тогтнолоо сэргээхийг ар, өвөр Монголчуудын аль аль нь ч хүсч байгааг илэрхийлсэн ажээ.

Ц. Ханддоржийн идэвхтэй оролцоотойгоор Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээх асуудал ингэж сэдэгдэж хөрш Орос улсаас тусламж эрхээр шийдсэн явдал бол тухайн үед үндэсний эрх чөлөөний тэмцлийг ялалтад хүргэж болохуйц ганц зам байлаа.

Монголын төлөөлөгчид маш нууц байдлаар 1911 оны 7-р сард Хүрээнээс уван цуван гарч Орос улсад явсан юм. Д. Ханддорж ийнхүү Орос улсад явахаас өмнө Их Жургаанаас 1911 оны 5-р арын 15-нд албан бичиг ирүүлж, Засагт тус хийх яамны хоёрдугаар хурлыг мөн оны 10-р сарын 22-нд эхлэхийн янар түүнийг 10-р сарын 11-нд нийслэлд ир! гэж зарлан дуудсан байв.¹⁸ Иймд Түшээт хан аймгийн эрх баригчид Ц. Ханддорж Бээжинд очих ёстой болзоот хугацааны өмнөхөн Хүрээний Манж амбанд, зарлигаар сонгосон хэлэлцэгч түшмэл, жанжин чин ван Ханддорж нийслэл орох замын зуур өвдөөд Засагт тус хийх яамны хуралдаанд очиж чадахгүй боллоо гэж хошуунаас нь мэдүүлээ хэмээн мэдэгдэж чөлөө гуйсан байна.¹⁹ Чин улсын эзэн хаан хариуд нь «Ханддоржид чөлөө шагнагун» гэж айлдсан ажээ.²⁰

Гэтэл Ц. Ханддоржийн хошууны туслагчаас 1911 оны 9-р сарын 28-нд Хан уулын чуулганы дарга, дэд дарга, Түшээт хан нарт албан бичиг ирүүлж, засаг, чин ван Ханддорж ноднин өвөл Хүрээнд очоод одоо болтол буцаж ирээгүй байна, хаана ямар албанд томилогдон явж байгаагийн нь сурагласан байдаг.²¹ Энэ баримт Д. Ханддорж сүүлийн жил гаруйн хугацаанд хошууны засгийн үүрэгт ажлаас хөндийрч үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолыг сэргээх чухал хэргээр оролдсон нь илэрхий байна.

Ц. Ханддорж тэргүүтэй Монголын төлөөлөгчид Орос улсын засгийн газартай хийсэн хэлэлцээгээр Монгол орныг Манж Чин гүрнээс бүрмөсөн тусгаарлан, Өвөр Монголыг оролцуулан монгол улсын төрийн тусгаар тогтнолыг сэргээн тунхаглах, шинэ Монгол улсыг Оросын албан ёсны өмөг түшигт оруулах тухай гаргасан саналыг Хаант засаг, бусад эзэрхэг түрэмгий гүрнүүдийн эсэргүүцэхээс болгоомжлон зөвшөөрсөнгүй. Харин Оросын хаант засаг Их хүрээ, Бээжингийн эрх баригчдын хооронд зуучилж, Манжийн засгийн газраас Монгол орныг колоничлох, Халхад цэрэг оруулах Монголд өөрийн засаг захиргаа байгуулах мэтийн өөрчлөлт хийх явдлыг болиулах арга зам сүвэгчлэхийг зөвшөөрчээ.²² Монголын төлөөлөгчдийн Орос улсад зорьж очсон хэрэг ийнхүү бүрэн биелээгүй ч гэсэн үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийн зориг мохсонгүй.

Тэднийг буцаж ирсний дараа Халхын хүрээний газраа том ноёд лам нар сэмхэн хуралдаж Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээх явдалд Жибзундамба хутагтын нөлөөг ашиглахын тул түүнд 1911 оны 11-р сарын 28-нд айлтгахдаа: «... одоо өмнө газар их самуун дэгдэж олон мужид шинэ төр байгуулан улс болон тогтнож буй чимээ машинд олон болсон ба Манжийн хаан аймагтны эрх мэдэл тун ч өчүүхэн болжээ. Иймд шавь нар бид бүхэн яахин хүмүүжвээс сайн болохыг тодорхойгоор айлдахыг хүснэ»²³ гэжээ. Энэ айлтгалаас үзэхэд Чин улсын гүнд гарсан хөрөнгөтний хувьсгал, Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтөд нөлөөлсөн нь илэрхий. Нөгөө талаар Чин улсын төр мөхөх гэж байгаа нь Монголын эрх баригчдад мэдэгдэж байжээ.

Жибзундамба хутагт хариу буулгасан лүндэндээ: «Таны ийнхүү асуусан нь маш сайн. Ер нь аливаа юманд цаг хэмжээгүй нь огт үгүй. Манж Хятадын энэ байдал мөн цаг болсны тулд болой. Одоо Монгол овогтон бүгдээрээ нийлж өөртөө улс болон тогтнож шашнаа мандуулан бусдын эрх мэдэлд дарлагдах зовлон зүдүүрийг үзэхгүй болох цаг болсон. Гэвч бүгдээрээ нэгэн сэтгэл, хамт хүчин гаргаж, чармайн зүтгэхийг харгалзана»²⁴ гэжээ. Монголын феодалууд үүнээс урьд «Язгуурын ёсоор аж төрөх» урианы дор Чин улсын шинэ засгийн бодлогыг эсэргүүцэж байсан бол энд «Монгол овогтон бүгдээрээ нийлж өөртөө улс болон тогтнож шашнаа мандуулах» шинэ уриа томъёолон гаргасан байна. Энэ бол Чин улсын ноёрхолын эсрэг монголчуудын тэмцэл шинэ шатанд дэвшиж үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон төлөвшсөнийг харуулж байна.

Жибзундамба хутагтыг Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гол удирдагч болгон өргөмжлөхийг хичээгчид энэ лүндэнг гол иш үндэс болгодог билээ. Гэтэл дээр дурдсан бүх баримт уг хөдөлгөөний гол удирдагч бол Жибзундамба хутагт биш харин Ц.Ханддорж байсныг энэ лүндэн буухаас өмнөх түүний үйл ажиллагаа нотлож байгаагаар барахгүй Монголын хар шар феодалууд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдлагыг хэрхэн гартаа авсныг харуулж байна.

III

Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухайн үеийн улс төрийн мөрийн хөтөлбөр нь тэрхүү Богдын лүндэн гэгчид тодорхойлогдсон юм.

Хүрэн дэх том ноёд, лам нар түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай хэлэлцээд Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээх хэргийг шууд эрхлэн удирдах байгууллага болох «Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар» гэгчийг чин ван Ханддорж оролцсон, 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.* Энэ бол санамсаргүй хэрэг биш ээ. Монголын феодалууд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдлагыг мэдэлдээ авч өөрсдийн ангийн эрх ашгийг илэрхийлэх байгууллага өөрөөр хэлбэл; Хүрэн дэх Чин улсын захиргааг түлхэн унагаж Монголын феодалын хаант улсыг сэргээх явдлыг бэлтгэн зохион байгуулах түр засгийн газрыг байгуулсан хэрэг мөн. Энэ байгууллага Жибзундамба хутагтын лүндэнг Дотоод Монголын засаг ноёд, Барга, Алашаа, Хөх нуур, Или Тарвагатайн зэрэг Монголчуудад яаралтай уламжлахдаа Монгол улсыг сэргээн мандуулж Жибзундамба хутагтыг Монгол улсын хаан ширээнд өргөмжлөх гэж байгааг нэгэн адил мэдэгдэж юуны урьд Халхын дөрвөн аймгаас нэгжгээд мянган цэрэг дайчлах тухай зарласан.

Тэр үед Их Хүрээ нь Халхын шарын шашны төв, зүүн хоёр аймаг ба их шавийн засаг захиргааны төв болж байлаа. Их Хүрээ болон түүний хавь нутгаас цэрэг дайчлах нь жанжин Ханддоржийн шууд мэдлийн асуудал байсан тул 1—2 хоногийн дотор Хүрээний ойрхи хошуудаас 500 орчим идэр залуу эрчүүд цэрэгт татагдаж ирсэн байна.²⁵

XIX зууны сүүлчээс Монголд үүсч өрнөсөн үндэсний эрх чөлөөний тэмцэлд Монголын нийгмийн үндсэн ангиуд болох ард, феодалын төлөөлөгчид хамрагдаж бие биеэсээ салангид тус бүр «өөрсдийнхөөрөө» оролцож эхэлсэн юм. Тэр нь нэг талаас Монголын нутгийг хятад иргэдээр

* Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа. УБ., 1971, 275-р талд; Жанжин чин ван Ханддорж түр зөвлөн шийтгэх түшмэлийн тушаалтай байсан гэж бичжээ.

дүүргэж, хүчээр хятадчилж уусгах Чин улсын бодлого нэн идэвхжсэн, нөгөө талаас хаант Орос, Япон зэрэг империалист гүрнүүд Монгол орныг нөлөөнийхөө хүрээнд хуваан колоничлох явдал мэдэгдэхүйц ширүүссэн үед Монголын ард, феодал ангиудын хоорондын тэмцлээс эх орноо харийн ноёрхолоос чөлөөлж, төрийн тусгаар тогтнолоо сэргээх явдал давамгайлж үндэсний эрх чөлөөний нэгдмэл хөдөлгөөн болон нягтрах явт эхэлсэн юм.

Ард түмэн тэмцлээрээ төрийн тусгаар тогтнолоор байлдан олж, үндэстний ба нийгмийн дарлал, мөлжлөгөөс ангижрахыг хүсч байсан бол феодалууд түүнийг ашиглан хаант Орос улсын дэмжлэгтэйгээр Чин улсын ноёрхолоос гарч Монголын феодалын эзэн хаант үндэсний нэгдмэл улсыг байгуулах, улс орноо хэнтэй ч хуваалцахгүй өөрсдөө бүрэн ноёрхохыг зорьж байв.

XX зууны эхний арван жилд гарсан Улиастайн цэргийн бослого, Сэцэн хан аймгийн ардын зарга тэмцэл, Засагт хан аймгийн ард Аюушийн хөдөлгөөн, Жирэмийн чуулганы Тогтох тайжийн удирдсан ардын бослого, Хүрээний ядуу лам нарын үймээн гэх зэрэг нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хөдөлгөгч хүчин-ард ангийн эрх чөлөөний тэмцлийн хурц илрэл мөн. Ард ангийн тэмцэл ийнхүү хурцдаж ирсэн нь хар шар феодалуудыг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцож, түүний удирдах хүчин болоход хүргэсэн ажээ. 1911 оны намар, өвлийн заагаас Ар Монголын эрх чөлөөний хөдөлгөөний урсгалд нийгмийн бүх анги давхарга хамрагдаж «үндэсний» шинжтэй болсон.

Хүрээн дэх Чин улсын захиргааны эсрэг Монголчууд зэвсэгт бослого эхлэх бэлтгэл түргэн хугацаанд хангагдсан боловч үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдах байгууллага нь шууд зэвсэг хэрэглэхийг урьдал болголгүй тайван замаар хүрээн дэх Чин улсын захиргааг хөөн зайлуулж Монголын төрийн тусгаар тогтнолыг тунхаглаж шашин төрийг хослон барьсан феодалын хаант улс байгуулсан. Жибзундамба хутагт Монгол улсын хаанаар өргөмжлөгдөөд буулгасан хишиг тараах зарлигтаа: «Тулгар төр байгуулах тухайн хэрэгт онц хүчин зүтгэж явсан Түшээт хан аймгийн засаг, хошой чин ван Ханддоржид үе улиран эрдэнэ-дайчин цол, ханы ямба, давхар пүнлүү, шар хүрэм, улбар шар жолоо, нэгэн үед ногоон жууз шагнаж шадар сайд, бүгд захирах сайд, гадаад хэргийг эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд тохоон талбигтун»²⁶ гэж бүх хишиг хүртэгчдийн хамгийн түрүүнд ийм тодорхойлолт, шагнал, цол хэргэм хүртээж албан тушаалд томилсон байдаг.

Монгол улсыг байгуулахад онц зүтгэсэн хүмүүст олгосон шагналын дотроос Ц.Ханддоржид ийнхүү хамгийн дээд зэргийн шагнал соёрхсон явдал бол түүний тэргүүлэх, удирдан зохион байгуулагч байсныг харуулж байгаа баримт мөн. Тулгар тогтсон Монгол улсыг дэлхий дахинд мэдэгдэж, гадаад олон улсаар зөвшөөрүүлэх явдал тухайн үндэсний эрх чөлөөний тэмцлийн тэргүүн зэргийн чухал зорилгын нэг болж тавигдсан үед Ц.Ханддоржийг Монгол улсын ГЯЯ-ны тэргүүн сайдаар томилсон нь Монголын тусгаар тогтнолыг сэргээх хэрэгт түүний гүйцэтгэсэн үүр гээр тайлбарлагдана. Ц.Ханддорж Монголын тусгаар тогтнолыг сэргээх бэхжүүлэх явдалд хөрш Орос улстай ойртож, түүний тусламж дэмжлэгийг авах нь шийдвэрлэх ач холбогдолтой гэж үзэж байв. Тийм ч учраас Монгол улсын ГЯЯ-ны тэргүүн сайдаар томилогдсоноос хойш Орос улстай ойртох, түүний өмгөөлөл, дэмжлэгийг ашиглан Монголын үндэсний нэгдмэл улсыг байгуулах оролдлого хийсэн юм.

Монголын хаант улсыг байгуулсны дараа үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь юуны урьд Ар Монголын нутгийг Чин улсын ноёрхлоос бүрэн чөлөөлөх, Өвөр Монголыг Хятадын түрэмгийллээс өмгөөлөх, Хөх нуур, Или Тарвагатайн Монголчуудыг хүртэл хамарч үндэсний нэгдмэл улс болох чиглэлээр гүнзгийрсэн билээ.²⁷ Түүнийг Монголын хаант улсын засгийн газраас удирдан зохион байгуулсан тул тэр үед Жибзундамба хутагт улсын хаан байсны хувьд уг үйл явдалд ямар нэг хэмжээгээр холбогдох нь мэдээж. Гэхдээ тэр нь Жибзундамба хутагтыг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гол удирдагч, Монголын тусгаар тогтнолын хэргийг санаачлагч гэж өргөмжлөх үндэслэл болж чадахгүй.

Ц. Ханддорж 1912 онд нийслэл Хүрээнд Орос улсын бүрэн эрхт төлөөлөгчтэй хийсэн хэлэлцээнд оролцсон. Тэгэхэд Оросын хаант засгийн Төлөөлөгч Монгол улсын эрх баригчдыг хуурч мэхлэх, сүрдүүлэх аргаар эрх тэгш биш хэлэлцээр байгуулж Монголын нэгэнт тунхагласан тусгаар тогтнолыг зөвхөн Хятадын харьяаны Ар Монголын автономии болгон хязгаарлах, түүнийг хаант Оросын улс төр, эдийн засгийн ноёрхолд оруулах үүдийг нээсэн билээ. Тэр үеийн дорно дахинд нэн ялангуяа Монголд автономии» гэдэг нэр томъёоны учир утга ойлгомжтой биш байлаа. «Автономный строй» гэдгийг уг хэлэлцээрийн монгол эхэд өөртөө тогтнож өөрөө эзэрхэг ёс журам» гэсэн байдаг. Үүнийг Ц. Ханддорж болон тэр үеийн Монголын бусад эрх баригчид «тусгаар тогтнол» гэдэг утгаар ойлгож байжээ. Ийм ч учраас 1912 оны эцсээр Ц. Ханддорж тэргүүтэй Монгол улсын төлөөлөгчид орос улсад очиж, нэгдмэл Монгол улсын төлөөлөгчид Орос улсад очиж, нэгдмэл Монгол улсын хил хязгаарыг Оросын засгийн газраар зөвшөөрүүлэх, түүнээс зээллэг авах тухай хэлэлцээ хийх, сурвалжлагчтай хийсэн ярилцлага зэрэгтээ Монголыг тусгаар тогтносон улс гэж нотлож байлаа* Гэтэл хэлэлцээний дүнд Оросын засгийн газар, Монголчуудын тусгаар тогтносон нэгдмэл улс байгуулах шаардлагыг зөвшөөрөхөөс татгалзаж Ар Монголд зөвхөн Ховдын хязгаарыг нэгтгэхийг дэмжих, Монголд зэвсэг нийлүүлэх, мөнгөн зээллэг олгох тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан. Ц. Ханддорж нар 1913 оны 3-р сар гартал Орос улсад байхдаа гадаад олон улсын элчин сайд нартай харилцаж, Монголын тусгаар тогтнолыг дэмжүүлэх оролдлого хийсэн боловч тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалж амжилт олоогүй.²⁸ Хэдүй тийм боловч Монгол улс Ц. Ханддоржийн гавьяа зүтгэлийг үнэлж 1913 онд «сайны удирдагч» цол шагнасан ажээ.²⁹

1913 оны сүүлчээр Орос, Хятад хоёр улс Монголын тусгаар тогтнолыг цуцлаж хятадын эзэн эрхийн дор байлгах, тэгэхдээ зөвхөн Ар Монголд автономит эрх олгох тухай тунхаглал гаргаж Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтийг бууруулсан нь Ц. Ханддоржийн дипломат шугамаар хийж буй тэмцэлд хүчтэй цохилт болсон.

Бүх дэлхий дээр империализм хуваарьгүй ноёрхож байсан тэр цагт Монголын тусгаар тогтнолын хувь заяа нь дан Монголчуудын тэмцэл

*Ц. Ханддорж Орос улсын ГЯЯ-ны сайдтай хэлэлцээ хийхдээ: “Монгол бол Орос Монголын хэлэлцээрээр Өвөр Монголыг багтаасан бүрэн тусгаар тогтносон улс болов гэж ойлгосонхэмээн мэдэгдэж байжээ. (И. Коростовец. Монголын ойр үеийн түүх) (Япон хэлээр) Токио, 1939. 371-рт” (Түүнчлэн Ц. Ханддорж 1913 оны 2-р сарын 14-нд Оросын «Новое время сонины сурвалжлагчтай хийсэн ярилцлагадаа: Монгол өөрөө өөрийгө захирдаг, болохоороо тусгаар тогтносон улс гэхээс өөр аргагүй юм» гэсэн байдаг. (Японы гадаад яамны баримт) (Япон хэлээр) 1913 он 441-рт

хүсэл эрмэлзлэл, хаант Орос улсаас Монголд шунахайран өнгөлзөж байгаагаар биш, харин түүнээс Монголыг хувааж колоничлох талаар бусад империалист улсуудтай байгуулсан хэлэлцээрүүд болон Алс Дорнод дахь олон улсын хүчний харьцаагаар тодорхойлогдох ёстой байжээ. Ийм нөхцөлд Ц. Ханддорж нарын зэрэг Монголын феодал ангийн дэвшилт төлөөлөгчид, Оросын хаант засгийн дэмжлэгээр Монголын тусгаар тогтнолыг бататгаж үндэсний нэгдмэл улс болох гэсэн оролдлого бүтэлгүй болж зөвхөн Ар Монгол Хятадын эзэн эрхийн дор автономит улс болох төдий гөөр хязгаарлагдсан билээ.

Ц. Ханддорж нарын 10-аад жилийн шаргуу тэмцэл мухардаж ирмэгц Монголын эрх баригчдын доторхи Хятадын талыг баримталсан этгээдүүдийн хагалан бутаргах, хорлон сүйтгэх ажиллагаа идэвхжиж 1915 оны эхээр үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагч, Монголын хаант улсын гадаад харилцааны анхны зүтгэлтэн Ц. Ханддорж хорлогдож нас барсан юм.³⁰ Ц. Ханддорж бол Монголын тусгаар тогтнолыг олон улсаар хүлээлгэн зөвшөөрүүлэхийн төлөө тууштай тэмцэгч байсан төдийгүй, тус оронд иргэний ерөнхий боловсролын сургуулийг үүсгэн хөгжүүлэх хэргийг санаачлан дэмжигч байлаа. Иймд тэр харьяат хошуугаа хэрхэн захирч, аж ахуй, соёлын талаар юу хийж байсан. Түшээт хан аймгийн цэргийг яаж зохион байгуулж байсан, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг Ар Монголд ялуулах хийгээд гадаад харилцааны шугамаар чухам юу юу хийж байсан. Тус оронд иргэний ерөнхий боловсролыг үүсгэн хөгжүүлэх талаар хийсэн ажил, хувийн амьдрал зэргий нь цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

Тэр феодалын улс төрийн зүтгэлтэн мөн боловч түүнээс Чин улсын ноёрхолыг эсэргүүцэж, Монголын үндэсний улсыг сэргээн байгуулж бэхжүүлэхийн төлөө олныг удирдан зохион байгуулж байсан нь дэвшилт үйл ажиллагаа гэж үзвэл зохино.

Тэр үед Монгол орон Орос улстай ойртсон нь цаашид монголын ард түмний төлөөлөгчид Оросын ажилчин тариачинтай ангийн холбоо тогтоож, үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо байлдан олох явдалд дөхөм болсныг тэмдэглүүштэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН НЭРС

1. Улсын Түүхийн Төв Архив (УТТА) ФМ-9, ХН-4059
2. М. М. Петухов Монгол нь Манж автономитын үед УБ., 1939. 85—86-рт
3. А. Каллинников. Аратское революционное движение в до-автономной Монголии «Революционный восток» 1934. No 6 с. 52
4. «Новый восток» сэтгүүл № 3. 1912. с. 146— 147
5. УТТА ФМ-9, ХН-3992
6. УТТА ФМ 9. ХН— 4081
7. УТТА ФМ—9. ХН—4102
8. Мөн тэнд
9. УТТА ФМ-9, ХН-4117
10. Мөн тэнд
11. УТТА фМ—9, ХН-4117
12. УТТА ФМ-9. ХН— 4137
13. Мөн тэнд хн-4136
14. УТТАфМ—9. ХН—4058
15. УТТА ФМ-9, ХН—4 123
16. Мөн тэнд
17. Л. Дэндэв, Монголын товч түүх. УБ. 1934. 3—4-р тал

18. УТТА ФМ-9. ХН-4125
19. Мөн тэнд ХН— 4136
20. Мөн тэнд
21. Мөн тэнд
22. БНМАУ-ын түүх, УБ., 1984, 304—305-р тал
23. УТТА ФА. т-1 ХН-1
24. Мөн тэнд
25. Ц. Пунцагноров. «Монголын автономит үеийн түүх» УБ., 1955 36-р тал
26. УТТА ФА—5, хН—511
27. Л. Жамсран «Монголын 1911—1913 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үечлэл, шинж чанарын зарим асуудал» — Олон улсын Монголч эрдэмтдийн их хурал, III боть. УБ., 1979. 181—186-рт
28. Б. Ширэндэв. Монгол Ардын хувьсгалын түүх УБ., 1969 43—44-рт «Зарлигаар тогтоосон Халхын Түшээт хан аймгийн ван гүнгүүдийн Шастир. Дэд дээд 4-р»
30. Ц Пунцагноров. Дурдсан зохиол 86-рт

ЧИНГИС ХААН (1162—1227)

ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор

Н. ИШЖАМЦ

XIII зууны эхэн үеийн Ази, Европод Чингис хаан, татар-монгол хэмээх нэрс хүчтэй цууриатаж, дэлхий нийтийн түүхийн тавцан дээр монголын феодалын эзэнт гүрэн гарч ирсэн билээ. Энэ нь нүүдэлчин Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдаж, ойр, холын олон орныг байлдан дагуулсан бөгөөд түүнийг анх Чингис хаан оройлон удирдаж гүйцэтгэсэнтэй холбоотой юм. Монголын феодалын байлдан дагуулал, Чингис хааны тухай олон орны түүхийн сурвалж, янз бүрийн эрдэмтний судалгаа байвч уг асуудлыг үнэлэн дүгнэх дээр санаа бодол жигдрээгүй хэвээр байна.

Дундад зууны үеэс эхлээд Чингис хаан, Монголын байлдан дагууллыг зарим түүхчид маш дэвшилттэй сайн явдал хэмээж, зарим нь туйлын харгис бурангуй үйлийн тоонд оруулж үздэг байсны аль аль нь учир дутагдалтай болохыг бодит судалгаа нотолж байна. БНМАУ-ын түүхчид 1950—1960-аад оны үеэс эхлэн Чингис хааны үйл ажиллагааг үнэлэн дүгнэхдээ XI зууны эцэс, XIII зууны эхний Монгол угсааны тархай бутархай олон аймаг, овгийг нэгтгэж, Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдах явдалд түүний оруулсан хувь нэмрийг зохих ёсоор нааштай үнэлж, бусад улс орныг байлдан дагуулсныг нь Ази, Европын улс түмний түүх, түүнчлэн Монголынхоо амьдрал хөгжилд ч сөрөг үүрэг гүйцэтгэж гэж үзсээр ирэв.

* Б. Я. Владимирцов, Чингис-хан. Берлин-Пг. —М., 1922. БНМАУ-ын түүх, УБ, 1984, Сайшаал, Чингис хааны товчоон. I—II боть. Хөх хот, 1987.

М. С. Капица. Еще раз о роли Чингис-хана в истории, -- «Вопросы истории» сэтгүүл, 1988. №7

Л. Н. Гумилёв, Апокритический диалог, - «Нева» сэтгүүл, 1988. №3

Н. Сэр-Оджав, Түүхийн үнэний асуудалд, — «Үнэн» сонин 1988. 7. 28